



ИВЭЭН ТЭТГЭЛЭГ, ХАНДИВ ТУСЛАМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

“М-Си-Эс Кока-Кола” компанийн хувьд “Байгаль орчин, нийгэм, засаглал”-ын бодлого болон Брэндийн өнгө төрхөд нийцсэн үйл ажиллагаа, санаачилга, контент зэргийг ивээн тэтгэх, хамтран ажиллах хэлбэрээр оролцох боломжтой байдаг.

Тодруулбал,

- Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн
- Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжсэн
- Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, хөтөлбөрт хамтын ажиллагаа өрнүүлэх эсвэл ивээн тэтгэх стратегийг баримталдаг.

Бид юуг дэмжих вэ?

- Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягтай хамааралтай үйл ажиллагаа, санал санаачилга
- Хог хаягдал цуглуулах, хог хаягдал дахин боловсруулах, усны менежмент, уур амьсгалын хамгаалалт зэрэг байгаль орчныг хамгаалах чиглэлд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр
- Тогтвортой хөгжлийн 17 зорилтод нийцсэн аливаа төсөл, хөтөлбөр
- Брэндийн өнгө төрхөд нийцсэн үйл ажиллагаа

Бид юуг дэмжихгүй вэ?

- **Улс төр, шашны холбогдолтой үйл ажиллагаа.**
Манай компани улс төрийн аливаа нэг нам бүлэг, шашны урсгалыг илүүд үзэж, дэмжлэг үзүүлэх боломжгүй.
- **Аль нэг тамирчин, багийг тусгайлан дэмжих боломжгүй.**
Бид “сагсан бөмбөг, гар бөмбөг” гэх мэт спортын төрлөөр нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаас гадна томоохон тэмцээн, уралдааныг дэмждэг.
- **Хувь хүмүүсийн хүсэлт.** Бид хувь хүний хүсэлтийг хүлээн авахгүй бөгөөд олон нийтийг хамарсан арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжинэ.
- **Хариуцлагатай маркетингийн бодлого.** Дэлхий даяар 13 ба түүнээс доош насны хүүхдэд чиглэсэн маркетинг хэрэгжүүлэхгүй байх “Хариуцлагатай маркетингийн бодлого”-ыг бид үйл ажиллагаандаа тусган ажилладаг. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчийн сонголтыг хүндэтгэж буй хэрэг юм.

- **Брэндийн өнгө төрхөд нийцээгүй:** Брэндийн өнгө төрхөд нийцээгүй томоохон арга хэмжээ, тоглолт, кино, клип гэх мэт
- Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд дахиж хамтран ажиллах боломжгүй.

Хамтын ажиллагааны хугацаанаас шалтгаалж тухайн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй холбоотой тогтмол тайлан гаргаж өгнө. Хэрэв таны хүсэлт дээрх шалгуур, шаардлагыг хангаж байвал доорх хаягаар хүсэлтээ илгээнэ үү.

И-мэйл хаяг: admin@mcsocacola.mn

Өргөдлийн хэлбэр, агуулгад тавигдах шаардлага:

- Өргөдөл нь нэг нүүрээс хэтрэхгүй байх
- **Хураангуй хэсэгт дараах мэдээллийг багтаах:**
 - Үйл ажиллагааны зорилго
 - Үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл
 - Хамрагдах оролцогчдын тоо
 - Хүсэж байгаа ивээн тэтгэлгийн хэлбэр, хэмжээ
 - Брэндийн өнгө төрх болон “Байгаль орчин, нийгэм, засаглал”-ын бодлоготой хэрхэн уялдаж буй талаар
 - Маркетингийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломж
 - Холбогдох бусад мэдээлэл

Хариу өгөх хугацаа

Маркетинг, Захиргаа, Олон нийттэй харилцах нэгж таны илгээсэн хүсэлтэд сар тутам бичгээр хариу өгөх тул тухайн үйл ажиллагаа болохоос сарын өмнө хүсэлтээ өгөхийг анхаарна уу.

Танд Баярлалаа